



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 1144

Баян-Овоо сум

Т.Мөнхнасанг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсэг, Төсөвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоол (төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай) 7,11 дүгээр хавсралт, 84 дүгээр тогтоолын 2,3 дугаар хавсралт (тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай), 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолын 1, 5, 6 дугаар хавсралт, Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 1/1536 дугаар албан бичгийг (чиглэл хүргүүлэх тухай) тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төмөрсүхийн Мөнхнасанг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс Ахлах "Б" бүлгийн багшаар томилон ажиллуулсугай.

2.Ажил хүлээлцэх комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Энхжаргал арга зүйч

Гишүүдэд: Л.Мягмарсүрэн багш

Ч.Сарангуа нярав

3.Т.Мөнхнасангийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комиссын дарга (М.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Т.Мөнхнасанг ТҮБД-4 шатлалаар буюу 1559000 (нэг сая таван зуун тавин есөн мянган) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн нэмэгдлийг 20 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

5. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Т.Мөнхнасанд үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



Ц.ЭНХМАА